

БНМАУ ТАГНА ТУВАТАЙ ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООСОН НЬ, ТҮҮНИЙ ТҮҮХЭН УЧИР ХОЛБОГДОЛ

*Д. Уламбаяр**

Монголын дипломатын түүхэнд ХХ зууны эхэн хагаст нэлээд жинтэй байр суурь эзэлж байсан нэгэн чиглэл нь Тагна Урианхай буюу Тагна Туватай харилцах явдал байлаа. Эл асуудал түүхэн тодорхой шалтгааны улмаас олон арван жилийн турш судлаачдын хувьд хаалттай эмзэг сэдвүүдийн нэг байсан бөгөөд 1990-ээд оны ардчилал, ил тод байдлын ач буянаар архивын олон баримт материал нийтэд хүртээл болж эхэлсэний үр дүнд Тагна Урианхайг тойрсон дипломат бодлого, үйл ажиллагааны учир холбогдол, зангилаа аажим аажмаар тайлагдаж байна.

1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын үеэс олон зууны турш нэгэн захиргааны дор хамт байсан, угсаа гарал, ахуй заншил ижил төстэй, шашин шүтлэг нэгтэй Тагна Урианхайг өөртөө нэгтгэн татах, нөлөө бүхий орнуудаар хүлээн зөвшөөрүүлэх явдал Монголын шинэ засгийн газрын гадаад бодлогын монгол туургатнаа нэгтгэх, хүчирхэг нэгдсэн Монгол улсыг байгуулах гол чиг шугамын чухал бүрэлдэхүүн хэсэг байлаа. 1921 оны ардын хувьсгалд бэлтгэх, түүний дараа байгуулах төр засгийн зүгээс хэрэгжүүлэх дотоод, гадаад бодлогыг судлан бэлтгэх хүрээнд Тагна Урианхайн асуудал байнга анхаарлын төвд байсан нь эдүгээ нэгэнт тодорхой болсон зүйл юм.

1920-иод оны эхний хагаст Тагна Урианхайн улс төрийн нөхцөл байдал Монгол, Зөвлөлт Оросын ялгаатай байр суурийн улмаас ихээхэн түвэгтэй байв. 1921 оны 7 дугаар сарын 1-нд Москвад Ж.Цэвээн (С.Бегзеев), Хоролхүнд тэргүүтэй Монгол Ардын Нам (МАН), Ардын түр засгийн газрын төлөөлөгчид Зөвлөлтийн Гадаад Хэргийн Ардын Комиссар (ГХАК) Г.В.Чичеринтэй уулзаж Тагна Урианхайн асуудлыг тухайлан хэлэлцжээ. Хэлэлцээний явцад Монголын төлөөлөгчид “Монгол, Урианхай овогтны ... нэгдэх” эрмэлзлэлийг Зөвлөлт Орос Улс (ЗОУ) дэмжвэл зохилтой гэж мэдэгдсэн байна. Энэ асуудлаар Г.В.Чичерины байр суурь төдий л тодорхойгүй байсан ч тэрбээр “ЗОУ Урианхайн хязгаарыг өөрийн дэвсгэр газар гэж огтхон ч үзэхгүй, ямар ч санаархал байхгүй” гэжээ. Цаашлаад “МАН Урианхайн хязгаарт улс төрийн тогтвортой цөм болох Урианхайн Ардын Хувьсгалт нам байгуулах чиглэлээр даруй ажиллаж эхлэх нь чухал. Тус намын тусламжтайгаар манай шинэ тактикийг явуулахад хялбар, эмзэг бус бөгөөд Урианхайн хязгаар нийт Монголын Федерацид орох болно”¹ гэж тодорхой мэдэгдсэн байна.

* Д.Уламбаяр - МУИС-ийн ОУХС-ийн докторант

Москвагийн уулзалтын төгсгөлийн шат нь Урианхай дахь оросын оршин суугчдын нутгийн захиргаан дээр суурилсан ирээдүйн статус, тэнд оросын цагаачдын сонирхлыг хамгаалах тухай зэрэг төдийлөн санал зөрөлдөөхөөргүй асуудлыг хэлэлцэхэд чиглэгджээ. Бүхэлд нь шинжвэл Монголын төлөөлөгчид Урианхайн хязгаарыг ойрын ирээдүйд Монгол Улсын хэсэг болох юм байна гэж төсөөлж байжээ. ГХАК-тын үзэж байснаар Урианхайн асуудал дан Монголд явуулах бодлогын хүрээнээс хальж түүхийн илүү өргөн учир холбогдолтой байжээ.

Урианхайг ЗОУ-ын бүрэлдэхүүнд үлдээвэл 1914 онд Туваг албан ёсоор ивээлдээ авсан Хаант Оросын бодлоготой адил болох байв. Цэвэр улс төр, үзэл суртлын талаас нь авч үзвэл большевик удирдлага Туваг Монголд болон алсдаа Хятадын хувьсгалчдад “өгч” Зөвлөлтийн интернациональч гадаад бодлогын уян хатныг товойлговол зохих байлаа гэж Оросын судлаач, доктор С.Г.Лузянин дүгнэсэн байна.

ОК(б)Н-ын ТХ-ны Сибирийн товчооны 1921 оны 6 дугаар сарын нэгэн тогтоолд: “Урианхайн хязгаарыг манай ивээлд авах нь улс хоорондын харилцаанд улс төрийн том алдаа болно... Бидний чиг шугам нь биднийг Хятад-Монголтой ойртуулахуйц байх ёстой... Монгол дахь Хятадын суверенитет, Урианхай дахь Ардын хувьсгалт автономит Монголын суверенитетэд ЗОУ үл халдана: Холбооны үндсэн дээр Монголын бүрэлдэхүүнд Урианхай орох болно”² гэжээ. ГХАК-тын зарим удирдлага хэрэв Хятадын бүрэлдэхүүнд Монгол орвол Туваг тусгаар тогтносон байдлыг хадгалж, ЗОУ, Монголын дунд “халхавч” болох ёстой гэж үзэж байлаа.

Харин энэ үеэр Б.Шумяцкий Монгол-Зөвлөлтийн харилцааны хэтийн төлвийг үнэлэн Г.В.Чичеринд өргөсөн нэгэн бичигтээ: “Монгол улс төлөвших явц хараахан дуусаагүй, түүний төр, олон улсын байдал ямар төрх хэлбэр олох нь төдий л мэдэгдээгүй байгаа учир Урианхайн хязгаарыг Монголд нийлүүлэх асуудал нээлттэй үлдэх ёстой” гэсэн байв. Энэ үзэл бодол, байр суурь цаашдаа бодлого болж, биеллээ олсон юм.

1921 оны 7 дугаар сард Бүх Тувагийн зохион байгуулах Их хурал болж тус хязгаарын ирээдүйн статусыг хэлэлцэхэд төлөөлөгчдийн дунд Туваг тусгаар улс болгох, Монголтой нэгдэх, ЗОУ-тай нийлэх гэсэн гурван янзын санал гарч иржээ. Хурлын эцэст тусгаар тогтносон “Бүгд Найрамдах Тагна-Тува Ард улс”-ыг байгуулах шийдвэр гарч, 22 зүйл бүхий Анхдугаар Үндсэн хуулийн төслийг хэлэлцэн баталсан байна. Гэтэл мөн үед Тувад оршин суугч оросууд Урианхайн хязгаарын Орос иргэдийн XII их хурал гэгчийг 1921 оны 7 дугаар сарын сүүлчээр хийж Холбоот Орос улсын Үндсэн хуулийн дагуу өөрийн Засгийг тогтоож “Зөвлөлт Оросын Автономит колонийн хязгаарын Хувьсгалт Хороо”-г байгуулсан ажээ.³ Энэ нь Туваг

Оростой нэгтгэх гэсэн бодлогын тодорхой илрэл байв. Ийнхүү хоёр засаг зэрэгцэн орших болсон нь улс төрийн тогтворгүй байдлыг даамжруулж байлаа. Энэ байдал яваандаа Урианхайн Хэмчигийн хошуунд бослого, хөдөлгөөн гарахад хүргэжээ. Иймд Монголын Засгийн газар хэрэг явдлыг яриа хэлэлцээний замаар шийдвэрлэхийг эрмэлзэж, Цэргийн Яамны сайд бөгөөд Урианхайн хязгаарыг илбэн тохинуулах сайд Хатанбаатар Магсаржавыг 1924 оны 7 дугаар сард Кызылд Бүрэн эрхт төлөөлөгчөөр томилж, тэрбээр ЗХУ-ын төлөөлөгч консул Я.Х.Давтянтай⁴ нэлээд удаан хугацаанд уулзан, хэлэлцээ хийсний эцэст сая нэг асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх болжээ.

Урианхайн Хэмчигийн хошууны захиргааны дарга Кичжие, зөвлөх Баянпунцаг нар Кызыл дэх Зөвлөлтийн консул Чичаевт 1924 оны 1 дүгээр сарын 18-нд өргөдөл гаргаж, түүндээ Урианхайн хязгаарыг Монгол улсад нэгтгэх хүсэлт гаргаад үүнийг ЗХУ-ын ГХА-ын комиссар Г.В.Чичеринд уламжилж өгөхийг мэдэгдсэн байна.

Элбэгдорж Ринчино 1924 оны 10 дугаар сарын 23-нд ОК(б)Н-ын Буриадын Хорооноос Нийслэл Хүрэн дэх Зөвлөлтийн элчин А.Н.Васильевт илгээсэн нууц ноотдоо Урианхайг Монголд нэгтгэх ёстой. 4-5 жилийн дараа Монгол нь өөрөө тэртээ тэргүй ЗХУ-д нэгдэнэ гээд үүнийг Г.В.Чичеринд уламжлах нь зүйтэй гэжээ.

Зөвлөлтийн дипломат албаны тэргүүн Г.В.Чичерин 1925 оны 7 дугаар сард Улаанбаатар хотод шинээр томилогдсон элчин П.Н.Никифоровтой Москвад ярилцахдаа “Урианхайг бид Монголын нэгэн адил Хятадын ивээлд байгаа тусгайдаа Автономит Бүгд Найрамдах улс гэж үзэж байна. Ийм учраас нэгд, Урианхайг бид Монголд нэгтгэхийг эсэргүүцнэ. Бид Хятадын ивээл дор Бүгд Найрамдах Монгол Улсын автономит байдлыг хэлбэрийн хувьд зөвшөөрөн тунхагладаг. Гэхдээ бид практик дээр бол Монгол улс дотоод улс төр, эдийн засгийн байгууллаараа Зөвлөлт хэлбэрт ойртож очихуйц тийм ажил хийнэ. Хоёрт, Өвөр Монголыг Өөртөө нэгтгэх гэсэн Монголын Засгийн газрын санал, хүсэлтийг бид манай улс төрийн байдлын шалтгаанаар эсэргүүцэж байна. Хэрэв Монголыг нэгтгэвэл Хятадад үүнийг манай нөлөөллөөс болов хэмээн үзэж Хятадын олон нийтийн дургүйцлийг хөдөлгөнө” гэжээ.⁵

⁴ Давтян, Яков Христофорович (1888-1938) Гадаадад цагаачилж байгаад 1917 оны сүүлчээр Орост эргэж ирсэн. 1920-1921 онд Эстонд 1 дүгээр нарийн бичгийн дарга, Бүх Оросын Онцгой Комисст гадаад харилцааны хэлтсийн дарга, 1922 оноос ГХАК-тын гишүүн, Балтийн орнуудын хэлтсийн эрхлэгч, Литвад Бүрэн эрхт төлөөлөгч, 1922-1924 онд Хятадад Зөвлөлтийн төлөөлөгчийн газар зөвлөх, 1924 онд Тувад Бүрэн эрхт төлөөлөгч, 1925-1927 онд Францад, 1927-1930 онд Иранд, 1931-1934 онд Грект, 1934-1937 онд Польшид Бүрэн эрхт элчин байв.

Бүр 1921 оны Монгол-Зөвлөлтийн анхны хэлэлцээрийн үед Урианхайн хязгаарын асуудлыг Монголын төлөөлөгчдийн тэргүүн С.Данзан нилээд эрчимтэй тавьсан боловч түүнийг жич хэлэлцэхээр хойшлуулсан ажээ.

1924 оны 8 дугаар сарын 15-нд хоёр төлөөлөгч (Магсаржав, Давтян) тус хоёр орны аль аль тал Тагна Тувагийн дотоод хэрэгт оролцохгүй гэсэн албан мэдэгдэл нийтлүүлсэн байна. Гэхдээ мөн үед буюу 8 дугаар сард хуралдсан МАХН-ын III их хурал Туваг БНМАУ-ын бүрэлдэхүүнд эгүүлэн авах эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлсэн боловч 1924 оны 10 дугаар сард Бүгд Найрамдах Тува Ард Улсыг тунхаглаж, Үндсэн хуулийн төслийг баталжээ. 11 дүгээр сард хуралдсан Улсын Анхдугаар Их хурал дээр ГЯЯ-ны сайд А.Амар Урианхай бол Монгол улсын нэг хэсэг гэж дахин мэдэгдсэн байна.

МАХН-ын III Их хурал дээр ЗХУ-ын элчин А.Н.Васильев хэлсэн үгэндээ: “ах дүү нарын хооронд ч заримдаа хэрэлдэх, үл ойлголцох зүйл гардаг шүү дээ. Бидний дунд ч бас үл ойлголцох асуудал байдаг. Би үүнийг Урианхайн тухайн асуудалтай хамааруулан хэлж байна. Энэ асуудлыг бид тайван айван шийдэх болно. Хэн маань зөв, хэн маань буруутай болохыг бид одоогоор мэдэхгүй байна...” гэж бөөрөнхийлж байжээ.⁶

1925 оны 6 дугаар сард ерөнхий сайд Дондог тэргүүтэй Тувагийн төлөөлөгчид Москва одоож Зөвлөлт Засгийн газартай хэлэлцээ хийж, ЗСБНХУ БНТАУ-ыг хүлээн зөвшөөрснөөр Тагна Туваг Монголоос бүрмөсөн тасалжээ. 1926 оны 8 дугаар сарын сүүлчээр Зөвлөлт-Тувагийн Найрамдлын Гэрээнд тусгаар байдлаа харилцан зөвшөөрөх, дипломат төлөөлөгчөө солилцох тухай зүйл ангийг оруулж гарын үсэг зурсан байна.

1924 онд Кызыл дэх ЗХУ-ын консул Улаанбаатар дахь ЗХУ-ын Элчин төлөөлөгчийн газарт харъяалагдаж байжээ. Харин 1924 оны 5 дугаар сарын 31-ний Зөвлөлт, Дундадын хэлэлцээрээр Монгол дахь Хятадын бүрэн эрхийг ЗХУ хүлээн зөвшөөрснөөр 1925 оноос Кызыл дэх ЗХУ-ын консул Бээжин дэхь ЭСЯ-нд харъяалагдах болсон байна.

1926 оноос Кызыл дэх Зөвлөлтийн консул БНТАУ-д томилогдож, сая Тувагийн консул Москвад суух зөвшөөрөл олгогдов. 1929 оноос ЗХУ-ын элчин, худалдааны төлөөлөгч Кызылд, БНТАУ өөрийн элч төлөөлөгчдийг Москвад харилцан суулгажээ.

БНМАУ-аас Туваг тусгаарлахад чухал үүрэг гүйцэтгэсэн Зөвлөлтийн гол төлөөлөгчид нь алтайн ойрад Сергей Степанович Борисов, орос Алексей Григорьевич Старков, буриад Сирен Арабдунович Нацов (Шойжилов) нар юм.

С.С.Борисов иргэний дайны туршид Б.З.Шумяцкийн дэргэд байж, Коминтерний Алс Дорнодын газрыг төлөөлж байв. 1927-1928 онд Москвад ГХАК-тад ажиллаж Монгол, Тува, Түвдтэй харилцах асуудал эрхэлж, 1929 онд Алс Дорнодын хэлтсийн эрхлэгч болжээ.

А.Г.Старков 1921 оноос Хүрээнд ажиллаж, Ринчинотой хамт МХЗЭ-ийг хариуцаж байв. Тэрбээр 1921 оны Тувагийн Их хуралд “Сибирийн Хувьсгалт Хороо”-г төлөөлж байсан оросын нэг бөгөөд 1924 онд Алтанбулаг, 1926 онд Кызылд консул байв. 1928 онд БНТАУ-д түр хамаарагч, 1929 онд Тувад томилогдсон Зөвлөлтийн анхны элчин болсон юм.

С.Ш.Нацов 1920-иад онд Монгол болон Тувад Коминтерний олон чухал даалгаврыг хэрэгжүүлж байв. 1927 онд тэрбээр Сүрэн хэмээх нэрээр Тувагийн Ардын Хувьсгалт Намын ТХ-ны гишүүн болсон байна.

ЗХУ, Коминтерний идэвхтэй явуулгаар 1925 оны 11 дүгээр сард БНМАУ-ын Улсын II Их хурал илгээлт явуулж “Тагна Тувагийн ард түмэн бусдын эрх мэдлээс ангижирахыг эрмэлзэн, тус орны эрх ашиг, газар шороог бусдад үл эдлүүлэн, өөрсдөө хамгаалан сахиж, аж амьдралыг сайжруулсугай хэмээн хүсэж байгаа явдалд ер тагталзан боогдуулах зүйл үгүйн дээр Монгол, Урианхайн ард түмэн эрх чөлөөгөө эдлэхийг хүсэн зорих явдал нэгэн чанар тул Монгол, Урианхай нар эрхбиш чинагч харилцан нэвтрэлцэж, эрдэм соёл ба аж ахуйн бат сайн холбоо найрамдлыг байгуулж, өөр өөрсдийн ард түмний эрх чөлөөг бататган, энх тайвнаар аж төрөн ... явахыг ... толилуулав” хэмээн мэдэгдэж БНМАУ Тагна Тува улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрснөө тунхагласан байна.⁷

Улмаар БНМАУ ба БНТТАУ-ын Засгийн газрын төлөөлөгчид “Монгол ба Тагна Тува хоёрын хооронд Найрамдлын холбоо байгуулах тухай” 12 зүйлтэй Гэрээ бичгийг 1926 оны 8 дугаар сарын 16-нд Улаанбаатар хотноо байгуулж, БНМАУ-ыг төлөөлж ГЯЯ-ны сайд В.Дорлигжав, БН Тагна Диваг (Тува) төлөөлж Бадамбазар, Санжаа нар гарын үсэг зуржээ. Гэрээ бичгийн оршилд: “Урьд Орос, Дундад, Монгол гурван этгээдийн Гэрээ бичиг байгуулах дор Тагна Урианхайн ардуудыг Автономит Гадаад Монголын харъяат болгож захируулсан боловч энэ завсар Монгол ба Тагна Тувагийн ард дор шинэ байдал тогтож, хуучны эзэрхэгийн үед байгуулсан аливаа Гэрээ бичгийг хүчин төгөлдөргүй болгон цөмийг устгаж ард түмэн эрх чөлөө олсныг” тэмдэглээд нэгдүгээр зүйлд: “БНМАУ-ын Засгийн газрыг БН Тагна Дивагийн Ардын Засгийн газар зөвшөөрөн хүлээв”. Хоёрдугаар зүйлд: “БН Тагна Дивагийн Ардын Засгийн газрыг БНМАУ-ын Засгийн газарт зөвшөөрөн хүлээв”.⁸

Гэрээний дөрөвдүгээр зүйлд: “БНМАУ-ын Засгийн газар БН Тагна Дивагийн Ардын Засгийн газрын дэргэд Бүрэн эрх барих төлөөлөгч суулгахаас гадна Тагна Дивагийн Ардын Засгийн газар лугаа зөвлөн хэлэлцэж бусад газар төлөөний түшмэл суулгаж болмой”, тавдугаар зүйлд: “БН Тагна Дивагийн Ардын Засгийн газар БНМАУ-ын Нийслэл Улаанбаатар хотод Бүрэн эрх барих төлөөлөгчийг суулгахаас гадна БНМАУ-ын Засгийн газар лугаа зөвлөн хэлэлцэж, нутгийн зах нийлэх газарт төлөөний түшмэлийг суулгаж болмой”.

Зургаадугаар зүйлд: Хоёр улсын хил хязгаарыг Монгол, Тагна Дива хоёрын нутгийн зах нийлсэн хил хязгаар газрыг хоёр этгээдийн Засгийн газраас дараа зөвлөн хэлэлцэж, тусгай комисс гаргаж нутгийн зураг цэсийг баримталж шинэчлэн тогтоохоор заасан байна. Гэрээний бусад зүйлд харилцан худалдаа хийх, гаалийн дүрэм журам тогтоох, утсан ба шуудан холбоог буй болгох, эрдэм соёлыг хөгжүүлэн бадруулахаар заасны үндсэн дээр хоёр орны харилцаа хөгжиж эхэлжээ.⁹

Найрамдлын Гэрээг үндэслэн 1928 оноос БНТАУ-ын Бүрэн эрх барих элчин төлөөлөгч Х. Ананд Улаанбаатарт, мөн онд БНМАУ-ын Бүрэн эрх барих элчин төлөөлөгч Самбаа Кызылд харилцан сууж, хоёр улс байнгын элчин яамаа нээн ажиллуулж эхэлжээ.” Ийнхүү Монгол улс Зөвлөлтийн нөлөө хүчтэй монгол угсааны эсгий туургатан “гуравдахь хөрш”-тэй болсон юм.

Харин 1944 оны 11 дүгээр сард БНТАУ нь ЗСБНХОУ-ын бүрэлдэхүүнд нэгдэж, Оросын Холбооны Автономит муж болсноор хоёр улсын элчин харилцаа дуусгавар болсон юм.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. С.Г.Лузянин. “Россия-Монголия-Китай в первой половине XX века”. М., 2000. с. 18
2. Мөн тэнд
3. “Орос дахь Монгол угсааны улсууд”. УБ., 1995. 97 дахь тал
4. Д.Шүрхүү. “Монголо–Тувинские отношения, позиция России: первая половина XX века”. Автореф. канд. дисс. УБ., 1999. с. 15
5. “Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичгүүдэд”. 1 боть. (1920-1931 он) УБ., 2005, 153 дахь тал
6. МАХН-ын III Их хурал. 1924 он. 101 дэх тал
7. Б.Лхамсүрэн. “Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол”. УБ., 1995. 58 дахь тал
8. ГХТА .Ф-62. ХН-62. “Монгол ба Тагна-Дива хоёрын хооронд Найрамдлын Холбоо байгуулах тухай Гэрээ бичиг”. 1926.8.16
9. Мөн тэнд.

⁹ БНМАУ-аас БНТАУ-д сууж байсан элчин сайдууд: Самбаа 1928-1929, М.Дугаржав 1929-1931, Заяат 1932-1934, Д.Догсом 1934-1935, Гомбожав 1935-1936, Д.Намсрай 1936-1937, Шагдар 1937-1939, М.Дугаржав 1939-1941, Н.Ядамжав 1941-1944, БНТАУ-аас БНМАУ-д Х.Ананд 1928-1929, О.Харцага 1929-1931, К.Сунгар-Оол 1931-1935, Ө. Достай-Оол 1935-1936, Ш.Лувсанбуу 1936-1937, И.Балдан-Оол 1937-1938, Х.Намсрай 1938-1941, О.Охэмчиг 1941-1943, И.Бадраа 1943-1944 он